



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2022 оны 4 дүгээр
сарын 20-ны өдөр


Дугаар 57

Улаанбаатар
хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
удирдамж батлах тухай


1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг байгуулах, Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулж, 2022 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (Б.Жавхлан)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Ерөнхий сайдын 2022 оны 57 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ
ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ
УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч
Б.Жавхлан
- Дэд дарга: -Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт
- Гишүүд:
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
Б.Бат-Эрдэнэ;
 - Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр;
 - Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг;
 - Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар;
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
А.Ариунзаяа;
 - Барилга, хот байгуулалтын сайд
Б.Мөнхбаатар;
 - Боловсрол, шинжлэх ухааны сайд
Л.Энх-Амгалан;
 - Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар;
 - Соёлын сайд Ч.Номин;
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
З.Мэндсайхан;
 - Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан;
 - Эрчим хүчний сайд Н.Тавинбэх;
 - Эрүүл мэндийн сайд С.Энхболд;
 - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын Захирагч Д.Сумъяабазар;

-Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн
(зөвшилцсөнөөр);

-Үндэсний статистикийн хорооны дарга
Б.Батдаваа (зөвшилцсөнөөр);

-Хүний эрхийн үндэсний комиссын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан
(зөвшилцсөнөөр);

-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч
Д.Рэгдэл;

-Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг;

-Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн
дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр;

-Цөмийн энергийн комиссын Ажлын албаны
дарга Г.Манлайжав;


-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын дарга Б.Цэнгэл;

-Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны
ерөнхийлөгч С.Эрдэнэбат (тохиролцсоноор);

-Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн
танхимын ерөнхийлөгч О.Амартүвшин
(тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга Х.Батжаргал.



Ерөнхий сайдын 2022 оны 57 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Ажлын хэсэг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.1, 6.5.2, 6.5.3, 6.5.4, 6.5.5, 6.5.6, 6.5.7-д заасан Монгол Улсын дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулна.

Хоёр.Ерөнхий зүйл

2.1.Ажлын хэсэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогод үндэслэн Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал”-ыг баримталж ажиллана.

Гурав.Хийх ажлууд

3.1.Ажлын хэсэг нь дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ:

3.1.1.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах Ажлын дэд хэсгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.2.Ажлын дэд хэсгийн төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.1.3.Бодлогын баримт бичгийн төсөл болон холбогдох материал боловсруулж, эцэслэхэд Ажлын дэд хэсэгт чиглэл өгөх;

3.1.4.Олон улсын сайн туршлагыг төсөл боловсруулах үе шатанд хэрэглэх эсэхийг нягталж, шийдвэрлэх;

3.1.5.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл хоорондын бодлогын уялдаа, нийцлийг хангаж, давхардал, хийдлийг арилгах ажлыг зохион байгуулах;

3.1.6.Ажлын дэд хэсгийн ажлын явцтай танилцаж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.7.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажилд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн төлөөллийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх;

3.1.8.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийн боловсруулалтад нөлөөлөх хууль тогтоомжийн шинэчлэл болон бусад хүчин зүйлийг харгалзан, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.9.Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.

---o0o---